



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2017 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/332

Улаанбаатар хот

Магадлан итгэмжлэл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь заалт, Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн хурлын шийдвэр, Эрүүл мэндийн хөгжлийн төвийн эрүүл мэндийн байгууллагуудад хийсэн хяналт, шалгалтын дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур үзүүлэлтийг хангасан эрүүл мэндийн байгууллагуудыг хавсралтаар баталж, батламжийг олгосугай.

2. Магадлан итгэмжлэлийн шинжээчдийн багийн өгсөн зөвлөмжийг “Тусламж, үйлчилгээний чанарын хөгжлийн хөтөлбөр”-т тусган батлуулж, хэрэгжүүлэхийг магадлан итгэмжлэгдсэн эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Эмнэлгийн тусламжийн газар /Я.Буянжаргал/-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Очирбат/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



А.ЦОГЦЭЦЭГ

081063

Эрүүл мэндийн сайдын
2017 оны 08 сарын 29 -ны өдрийн
дугаар тушаалын хавсралт



**Эрүүл мэндийн байгууллагыг магадлан итгэмжлэх шалгуур
үзүүлэлтийг хангасан эрүүл мэндийн байгууллагууд**

№	Эрүүл мэндийн байгууллагын нэрс	Батламжийн дугаар	Магадлан итгэмжлэгдсэн хугацаа	Магадлан итгэмжлэл эхлэх огноо	Магадлан итгэмжлэл дуусах огноо
1.	“Амин-Эрдэнэ” ХХК-ний эмнэлэг	113/2017	2 жил	2017-07-04	2019-07-04
2.	“Бурамномиун” ХХК-ний эмнэлэг	114/2017	3 жил	2017-07-04	2020-07-04
3.	“Интерферон альфа” ХХК-ний эмнэлэг	115/2017	3 жил	2017-07-04	2020-07-04
4.	“Халиун толгой” ХХК-ний эмнэлэг	116/2017	4 жил	2017-07-04	2021-07-04
5.	“Ливерген” ХХК-ний эмнэлэг	89/2017	3 жил	2017-07-04	2020-07-04